



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/140/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежерийн үүргийг түр

орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: [zayag@audit.gov.mn](mailto:zayag@audit.gov.mn)

Интер аудит ХХК

Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг

Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: [altan\\_fin@yahoo.com](mailto:altan_fin@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	14
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит .....	14
4.2.1 Залруулсан алдаа.....	14
4.2.2 Төлбөрийн акт.....	14
4.2.3 Албан шаардлага .....	15
4.2.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮДТ	Үр дүнгийн тайлан

## 1.Аудитын санал дүгнэлт



### ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс:7046-36-12

2022.02.22 № 1302/146

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН  
ХҮҮХДИЙН 3-Р ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Г.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тосонцэнгэл сумын хүүхдийн 3-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*Пост, эргүүлийн хоолны материалын /мах, өндөг/ зарцуулалтыг бодит байдлаас хэт өндрөөр тооцож хоолны зардлыг 3.2 сая төгрөгөөр үрэлгэн зарцуулсан, ажилтнуудаа 2.4 сая төгрөгийн формын болон хөдөлмөр хамгааллын хувцас бэлтгэсэн зэрэг зөрчил нь (Төсвийн тухай хуулийн 6.4.1; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.1.4, 20.2.5-д тусгагдсан заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй) байна.*

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

012025398

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>71,077.98</u></b>	<b><u>52,051.08</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	8,042.69	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8,042.69	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	63,035.29	52,051.08
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,883.50	4,560.20
35110	Тусгай зориулалттай материал	4,143.50	4,400.20
35130	Эм боох материал	1,740.00	160.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	57,151.79	47,490.88
35410	Бичиг хэргийн материал	477.20	-
35420	Аж ахуйн материал	22,032.16	11,470.01
35440	Түлш, шатах тослох материал	13,309.00	8,230.00
35460	Хүнсний материал	1,276.59	5,217.23
35470	Бусад хангамжийн материал	20,056.84	22,573.64
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>20,977.01</u></b>	<b><u>27,086.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	20,977.01	27,086.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	14,197.38	20,718.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,339.14	4,339.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,073.74)	(1,194.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,784.20	31,496.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,958.74)	(16,228.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,555.35	7,555.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,527.92)	(5,278.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,826.63	16,826.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,777.53)	(16,826.63)
39217	Ном	30.00	30.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,779.63	6,367.13
39301	Програм хангамж	2,090.00	2,090.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(474.38)	(886.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,164.00	5,164.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>92,054.99</u></b>	<b><u>79,137.09</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>92,054.99</u></b>	<b><u>79,137.09</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	92,054.99	79,137.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,164.00	5,164.00
51101	Өмч: - төрийн	5,164.00	5,164.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	86,890.99	73,973.09
51210	Өмнөх үеийн үр дүн	86,890.99	86,890.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12,917.90)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>92,054.99</u></b>	<b><u>79,137.09</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>245,402.41</b>	<b>254,902.58</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,999.00</b>	<b>231,793.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,999.00	1,482.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,999.00	1,482.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,999.00	1,482.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	230,311.70
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	230,311.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>240,403.41</b>	<b>23,108.88</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,199.81	9,906.28
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,199.81	9,906.28
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	12,123.90	13,202.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,123.90	13,202.60
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	217,079.70	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	217,079.70	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>218,190.78</b>	<b>267,820.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,190.78</b>	<b>267,820.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	193,219.55	249,340.12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	152,584.81	171,355.84
210101	Үндсэн цалин	152,584.81	123,609.34
210102	Нэмэгдэл	-	33,745.10
210104	Урамшуулал	-	14,001.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,044.15	22,103.36
210201	Тэтгэврийн даатгал	13,064.93	15,586.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,505.85	1,717.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,204.68	1,370.85
210204	Ажилгүйдлийн даатгал	295.87	305.47
210205	Эрүүл мэндийн даатгал	2,972.82	3,122.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	369.94	17,489.00
210301	Гэрэл, цахилгаан	324.94	180.00
210302	Түлш, халаалт	-	17,309.00
210303	Цэвэр, бохир ус	45.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,312.60	15,538.75
210401	Бичиг хэрэг	337.30	1,291.70
210402	Тээвэр шатахууны зардал	-	303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700.00	700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,275.30	13,244.05
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,781.83	16,619.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	855.10	5,157.10
210502	Хоол, хүнс	11,408.43	11,410.76

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,518.30	51.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	792.60
210604	Урсгал засвар	-	792.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	300.00	784.90
210702	Дотоод албан томилолт	300.00	784.90
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	374.00	506.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224.00	150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	356.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,452.23	4,149.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,515.40	1,546.90
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,936.83	2,602.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,971.23	18,480.36
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,199.81	9,906.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,199.81	9,906.28
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	13,771.42	8,574.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,771.42	8,574.08
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>27,211.63</u></b>	<b><u>(12,917.90)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	18,499.43	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	18,499.43	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(18,499.43)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>8,712.20</u></b>	<b><u>(12,917.90)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,164.00	-	86,890.99	92,054.99
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,164.00	-	86,890.99	92,054.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,164.00	-	86,890.99	92,054.99
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,917.90)	(12,917.90)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,164.00	-	73,973.09	79,137.09

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>240,403.41</u></b>	<b><u>253,420.58</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>230,311.70</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	230,311.70
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	230,311.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>240,403.41</b>	<b>23,108.88</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,199.81	9,906.28
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,199.81	9,906.28
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	12,123.90	13,202.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,123.90	13,202.60
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	217,079.70	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	217,079.70	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>238,753.41</u></b>	<b><u>244,708.78</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>238,753.41</b>	<b>244,708.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>213,782.19</b>	<b>226,228.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	156,718.05	165,878.02
210101	Үндсэн цалин	109,937.72	120,122.01
210102	Нэмэгдэл	36,095.55	32,020.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	300.00	-
210104	Урамшуулал	10,384.78	13,735.96
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,953.60	19,538.50
210201	Тэтгэврийн даатгал	16,152.50	12,983.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,700.30	1,502.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,360.20	1,347.40
210204	Ажилгүйдлийн даатгал	340.10	336.90
210205	Эрүүл мэндийн даатгал	3,400.50	3,368.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,815.94	12,410.00
210301	Гэрэл, цахилгаан	324.94	180.00
210302	Түлш, халаалт	11,446.00	12,230.00
210303	Цэвэр, бохир ус	45.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,499.40	4,499.40
210401	Бичиг хэрэг	757.70	757.70
210402	Тээвэр, шатахуун	303.00	303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700.00	700.00
210404	Ном, хэвлэл	56.80	56.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,681.90	2,681.90
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,605.80	20,014.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,595.10	2,545.10
210502	Хоол, хүнс	10,492.40	14,901.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,518.30	2,568.30

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	792.60
210604	Урсгал засвар	-	792.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	300.00	784.90
210702	Дотоод албан томилолт	300.00	784.90
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	374.00	506.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224.00	150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	356.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,515.40	1,803.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,515.40	1,803.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,971.23</b>	<b>18,480.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,199.81	9,906.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,199.81	9,906.28
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	13,771.42	8,574.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,771.42	8,574.08
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,650.00</u></b>	<b><u>8,711.80</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,650.00</b>	<b>8,711.80</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,650.00</b>	<b>8,711.80</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,650.00	8,711.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650.00	8,711.80
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,650.00)</u></b>	<b><u>(8,711.80)</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	251,445.30	234,940.22
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	251,445.30	234,940.22
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	251,445.30	234,940.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	168,426.60	165,878.02
210101	Үндсэн цалин	117,120.60	120,122.01
210102	Нэмэгдэл	38,065.30	32,020.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500.00	-
210104	Урамшуулал	12,740.70	13,735.96
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,737.60	19,538.50
210201	Тэтгэврийн даатгал	16,000.50	12,983.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,684.30	1,502.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,347.40	1,347.40

210204	Ажилгүйдлийн даатгал	336.90	336.90
210205	Эрүүл мэндийн даатгал	3,368.50	3,368.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,410.00	12,410.00
210301	Гэрэл, цахилгаан	1,700.00	180.00
210302	Түлш, халаалт	9,500.00	12,230.00
210303	Цэвэр, бохир ус	1,210.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,499.40	4,499.40
210401	Бичиг хэрэг	757.70	757.70
210402	Тээвэр, шатахуун	303.00	303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700.00	700.00
210404	Ном, хэвлэл	56.80	56.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,681.90	2,681.90
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	30,699.80	20,014.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,545.10	2,545.10
210502	Хоол, хүнс	25,586.40	14,901.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,568.30	2,568.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	792.60	792.60
210604	Урсгал засвар	792.60	792.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	852.40	784.90
210702	Дотоод албан томилолт	852.40	784.90
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	511.50	506.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	511.50	356.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,515.40	10,515.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,515.40	10,515.40
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	0.015	0.015
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.007	0.007
620003	Үйлчлэх ажилтан	0.007	0.007

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,906.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,906.28</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,906.28
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,906.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,906.28
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	9,906.28
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,906.28
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,906.28

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 16-ны өдрийн №04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тосонцэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг Бага насны хүүхэд бие, оюун ухаан, сэтгэлээрээ эрүүл өсөн бойжих, өөрийн онцлог бүтээлч үйлээрээ, бусдын дэмжлэгтэйгээр танхим болон гэр бүлийн орчинд хөгжих, бие бялдар танин мэдэхүй, нийгэмшихүй чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн сургуульд бэлтгэхэд оршино. Зорилтын хүрээнд сургалт үйл ажиллагаага явуулсан, хамран тойргийн 3-5 насны хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулаж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 251.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 2.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	8,042.69	-	(8,042.69)
Бараа материал	63,035.29	52,051.08	(10,984.21)
Үндсэн хөрөнгө	20,977.01	27,086.00	6,108.99
<b>Нийт хөрөнгө</b>	<b>92,054.99</b>	<b>79,137.09</b>	<b>(12,917.90)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	92,054.99	79,137.09	(12,917.90)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>92,054.99</b>	<b>79,137.09</b>	<b>(12,917.90)</b>

Авлага дансны үлдэгдэл 8.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлага барагдаж дууссантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 11.0 сая төгрөгөөр буурсан нь 38.1 сая төгрөгөөр бараа материал худалдан авч, 1.5 сая төгрөгийн эм боох материал болон хүнс үнэ төлбөргүй хүлээн авч, 50.6 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6.1 сая төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагын шийдвэрээр 8.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийж, 2.6 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 252.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 252.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 230.3 сая, орон нутгийн төсвөөс 13.2 сая, нийт 243.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 234.9 сая төгрөгийг зарцуулж, 8.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

2021 онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр дээд шатны төсвийн захирагчаас 9.9 сая төгрөгийн санхүүжилт авч, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжинд 9.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу үнэн зөв мэдээлээгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Хөрөнгө зарцуулах шийдвэрийг буруу мэдээлсэн, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг өссөн дүнгээр мэдээлээгүй зөрчил илэрсэн.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд дараах зөвлөмжийг өгсөн аудитаар илэрсэн 8.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, зөвлөмж өгөгдсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2020 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет бус хөрөнгөд бүртгэлтэй Си Ти Эс санхүүгийн программын ашиглалтын давуу болон сул талыг одоогийн программтай харьцуулан дүгнэлт гаргаж, дээд шатны байгууллагад хандан шийдвэрлэж зохих арга хэмжээг авч ажилласан эсэхийг шалгах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

### 4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 16.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10.2 сая төгрөгийн алдааг залруулж, 4.2 сая төгрөгийн алдаанд төлбөрийн акт, 1.7 сая төгрөгийн алдаанд албан шаардлага хүргүүлжээ.

#### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 10.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

- ✓ Үнэ төлбөргүй авсан 1.5 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ УСНББОУС 12 Бараа материал иж бүрэн байх батламж мэдээдлийг зөрчиж байх тул тайланг засварлуулах.

2.1. Илрүүлэлт:

- ✓ Мөнгөөр бэлтгэсэн 8.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үйл ажиллагааны зардлаар тайлагнасан.

2.2. Шийдвэрлэлт:

- ✓ УСНББОУС 2 Мөнгөн гүйлгээний тайлан үнэн зөв байх батламж мэдээдлийг зөрчиж байх тул тайланг засварлуулах.

#### 4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ Ажилчдад 1.04 сая төгрөгийн формын хувцас авсан.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.6 заалтыг үндэслэн норм нормативгүй олгосон формын хувцасыг төлүүлэхээр акт тогтоох.

2.1. Илрүүлэлт:

- ✓ *Пост, эргүүлийн хоолны материалын /мах, өндөг/ зарцуулалтыг хэт өндөрөөр буюу 3.2 сая төгрөгөөр илүү тооцож хоолны зардлыг үндэслэлгүй өсгөсөн.*

2.2. Шийдвэрлэлт:

- ✓ *МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.6 заалтыг үндэслэн норм нормативыг үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулсан хоолны зардлыг эргүүлэн төлүүлэхээр акт тогтоох.*

**4.2.3 Албан шаардлага**

1.1. Илрүүлэлт:

- ✓ *Ажилчдад 1.4 сая төгрөгийн нормын хувцас олгосон.*

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ *Төсвийн тухай хуулийн 6.4.1, ЗГ-ын 43р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлж байна.*

2.1. Илрүүлэлт:

- ✓ *Иргэдээс бэлтгэсэн махыг зах зээлийн үнээс өндөр үнээр буюу 0.3 сая төгрөгөөр өндөр худалдан авсан.*

2.2. Шийдвэрлэлт:

- ✓ *МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.1.4 заалтыг үндэслэн зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгө олж бэлтгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.*

**4.2.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	Тосонцэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг	6	16.1	2	10.2	2	4.2	2	1.7		
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>16.1</b>	<b>2</b>	<b>10.2</b>	<b>2</b>	<b>4.2</b>	<b>2</b>	<b>1.7</b>		